



МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ХӨГЖИЛ,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2015 оны 02 сарын 18 өдөр

Дугаар А/30

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах
тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1, 24.2 дахь заалт, Нийгмийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Иргэн /даатгуулагч/-д эмнэлгийн хуудас олгох журам"-ыг нэгдүгээр, "Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох бүртгэл"-ийн маягыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Ц.Уртнасан/-т даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2009 оны "Журам батлах тухай" 124 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



С.ЭРДЭНЭ

Хүн амын хөгжил, нийгмийн
хамгааллын сайдын 2015 оны 02
дугаар сарын 18-ны өдрийн
... дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

ИРГЭН (ДААТГУУЛАГЧ)-Д ЭМНЭЛГИЙН ХУУДАС ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар "Нийгмийн даатгалын тухай хууль"-ийн 4 дүгээр зүйлийн 2, 3, 6 дахь хэсэгт заасан даатгуулагч (цаашид "Даатгуулагч" гэх), ердийн өвчин, ахуйн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин (цаашид YOMШӨ гэх)-ний улмаас хөдөлмөрийн чадвар түр алдах (цаашид "ХЧТА" гэх), түүнчлэн жирэмсний болон амаржсаны тэтгэмж тооцох үндсэн маягт болох эмнэлгийн хуудсыг хэвлүүлэх, олгох, хөтлөх, хяналт тавих харилцааг зохицуулна.

1.2. "Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль"-ийн 4 дүгээр зүйлд заасан цэргийн албан хаагчид эмнэлгийн хуудас олгох, хяналт тавихад энэхүү журмыг мөрдөж болно.

1.3. Эмнэлгийн хуудас нь нэгдсэн дугаартай, хэвлэмэл маягт байх ба хэвлүүлэх, хүргүүлэх ажлыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (цаашид НДЕГ гэх) хариуцна.

Хоёр. Эмнэлгийн хуудас олгох (бичих) хугацаа

2.1. "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль"-ийн 17, 19, 19¹, 19², "Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль"-ийн 13,14,15 дугаар зүйлд тус тус заасныг үндэслэн хөдөлмөрийн чадвараа түр алдсан болон жирэмсэн, амаржсан даатгуулагчид эмнэлгийн хуудас олгоно.

2.2. Эмнэлгийн хуудсыг нийгмийн даатгалын дэвтэр, өвчний түүх, амбулаторийн карт, YOMШӨ-ний акт, эмнэлэг хяналтын комиссын шийдвэр, түр оршин суугчид баг (хороо)-ийн Засаг даргын тодорхойлолт зэргийг үндэслэн олгоно.

2.3. Даатгуулагчид эмнэлгийн хуудсыг дараах Төрийн болон хувийн хэвшлийн, холимог өмчийн эрүүл мэндийн байгууллага (цаашид эрүүл мэндийн байгууллага гэх) олгоно. Үүнд:

- а/ Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага;
- б/ Ор бүхий хувийн хэвшлийн эмнэлэг;
- в/ Холимог өмчийн эрүүл мэндийн байгууллага;

г/ Рашаан сувиллын клиник тасаг;

д/ Уламжлалт анагаах ухааны төв;

2.4. Эмнэлгийн хуудсыг дараах байдлаар олгоно.Үүнд:

2.4.1. Ердийн өвчин болон ахуйн осол, ҮОМШӨ-өөр өвчилж стационар, амбулаториор эмчлүүлсэн, хүүхдээ 196 хоног хүртэл тээгээгүй дутуу төрүүлсэн, эмнэлгийн заалтаар үр хөндүүлсэн болон жирэмсэн ба амаржсан даатгуулагчид тусламж үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллага;

2.4.2. Эмнэлэгт өвчтөн илгээх хуудас (яаралтай тусламж авч буй даатгуулагчийн хувьд хамаарахгүй)-аар хүлээж авсан төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношлогоо эмчилгээний төв, рашаан сувилалын клиник тасаг зэрэг эрүүл мэндийн байгууллага;

2.4.3. Эмнэлгийн байгууллагын шийдвэрээр гадаадад эмчлүүлсэн, албан болон хувийн хэргээр гадаад оронд зорчиж байхдаа өвчилж, амбулаториор болон эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн тохиолдолд эмчлүүлсэн хугацааны эмнэлгийн хуудсыг өвчний онош, хийлгэсэн эмчилгээг үндэслэн илгээсэн болон харьяалах эмнэлгийн байгууллагын Эмнэлэг хяналтын комиссын шийдвэрээр;

2.5. Жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудсыг дараах байдлаар олгоно. Үүнд:

2.5.1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19¹ дүгээр зүйлд заасан жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүссэн нөхцөлд жирэмсний 31-32 долоо хоногтойд хяналт тавьж буй эрүүл мэндийн байгууллага олгоно.

2.5.2. Даатгуулагч жирэмсний эмнэлгийн хуудас авах хугацаанаас өмнө амаржсан тохиолдолд хяналтад авсан эмнэлгийн байгууллага жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудсыг давхардуулан олгож болно.

2.5.3. Гадаад оронд түр хугацаагаар амьдарч байгаа тохиолдолд тухайн орны эмнэлгийн байгууллагын жирэмсэн, амаржсаны тодорхойлолтыг үндэслэн байнга оршин суух бүртгэлтэй аймаг (дүүрэг)-ийн нутаг дэвсгэрт орших эмнэлгийн байгууллагын эмнэлэг хяналтын комиссын хурлын шийдвэрээр олгоно.

2.6. Энэ журмын 2.5.1.-т заасан болзлыг хангасан албан журмын даатгуулагч ажлын шаардлагаар үргэлжлүүлэн ажиллах бол жирэмсний амралт авсан өдрөөс эхлэн эмнэлгийн хуудсыг хяналтад авсан эмнэлгийн байгууллага олгоно.

2.7. Энэ журмын 2.5.1-т заасан болзлыг хангасан даатгуулагчид жирэмсний тэтгэмжийг авсан эсэхээс үл хамааран амаржсаны эмнэлгийн хуудсыг хяналтад авсан эмнэлгийн байгууллага олгоно.

2.8.Эмнэлгийн хуудас олгох хугацааг дараах байдлаар тодорхойлно:

2.8.1. ХЧТА-ны эмнэлгийн хуудсыг эмнэлгээс гарсан өдөрт нь, эсвэл эмчлүүлж дууссанаас хойш ажлын 5, гадаад оронд эмчлүүлсэн бол эх орондоо ирснээс хойш 30 хоногийн дотор олгоно.

2.8.2. Жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудсыг жирэмсний амралт эхэлснээс хойш болон амаржсан өдрөөс хойш 30, гадаад оронд жирэмсний хяналтанд байсан болон амаржсан тохиолдолд 60 хүртэл хоногийн дотор тус тус олгоно.

2.9. Дараах хүндэтгэн үзэх шалтгаанаар 2.8.-д заасан хугацаа хэтэрсэн тохиолдолд эмнэлгийн хуудсыг бичиж олгоно. Үүнд:

2.9.1 Гомдол гаргагч хүндээр өвчилсөн;

2.9.2. Хорио цээрийн дэглэм тогтоогдсон;

2.9.3. Байгалийн болон нийтийг хамарсан гамшиг тохиолдсон зэрэг өөрөөс нь үл хамаарах шалтгаанууд.

2.10. Энэ журмын 2.3-т заасан эмнэлгийн байгууллагаас олгох эмнэлгийн хуудсыг хэвтэн эмчлүүлсэн бол өвчний түүх, амбулаториор эмчлүүлсэн бол амбулаторийн карт, эмнэлэг хяналтын комиссын хурлын шийдвэрийг үндэслэн эмнэлгийн байгууллагын дүн бүртгэлийн их (бага) эмч, эмчлэгч их эмч бичнэ.

2.11. Амбулаториор эмчлүүлсэн даатгуулагчид эмчлэгч их эмч эмнэлгийн хуудсыг 14 хоногоос илүүгүй хугацаагаар олгоно. Хэрэв 14 хоногоос дээш хугацаагаар эмнэлгийн хуудас олгох шаардлагатай бол дараах байдлаар сунгана. Үүнд:

2.11.1. Өвчтөний биеийн байдал, шинжилгээний дүнг эмнэлгийн байгууллагын эмнэлэг хяналтын комисс 7 хоног тутамд хэлэлцэн эмнэлгийн хуудас бичих хугацааг сунгана.

2.11.2. Даатгуулагч хорт хавдар, сүрьеэ, ахуйн болон үйлдвэрлэлийн ослын улмаас удаан хугацааны эмчилгээ шаардсан өвчнөөр өвчилсөн тохиолдолд эмнэлгийн хуудсыг Эмнэлэг хяналтын комиссын хурлын шийдвэрээр нэг удаад 30 хүртэл хоногоор сунгана.

2.12. Эмнэлгийн хуудсыг бичихдээ өвчний оношийг олон улсын өвчний ангиллын шифрээр, өвчилсөн хугацааг хоёр цифрээр бичнэ.

2.13. Эмнэлгийн хуудсыг буруу бичсэн, засварласан, үрэгдүүлсэн бол хүчингүйд тооцох бөгөөд уг эмнэлгийн хуудасны дагуу тэтгэмж олгоогүй тухай ажил олгогчийн тодорхойлолтыг үндэслэн анх хуудас бичсэн эмнэлгийн байгууллага 14 хоногийн дотор дахин олгоно.

2.14. Эрүүл мэндийн байгууллагын дарга (захирал, эрхлэгч) эмнэлгийн хуудас бичсэн үндэслэлийг шалгаж, гарын үсэг зурж, эмнэлгийн тамга (тэмдэг)-аар баталгаажуулна.

2.15. Эмнэлгийн байгууллага нь эмнэлгийн хуудсыг засваргүй, гаргацтай бичиж даатгуулагчид олгох ба эмнэлгийн хуудас олгосон тухай "Даатгуулагчид эмнэлгийн хуудас

олгосон бүртгэл" хөтөлж бүртгэлийн нэг хувийг нутаг дэвсгэрийн нийгмийн даатгалын байгууллагад өгч сар бүр тооцоо хийнэ.

2.16. Эмнэлгийн хуудас олгох нийт хугацаа:

2.16.1. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсыг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1, 2 дугаар хэсэгт заасан даатгуулагч нь ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвар түр алдсан тохиолдолд 91 хоногийн эмнэлгийн хуудас олгоно.

2.16.2. Хорт хавдар, сүрьеэгээр өвчилсөн, ҮОМШӨ-ний улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдсан тохиолдолд нийтдээ 182 хоногоос хэтрэхгүй хугацаагаар эмнэлгийн хуудас олгоно.

2.16.3. Нийгмийн даатгалын тухай хуулийн 19¹-д заасан болзлыг хангасан даатгуулагчид жирэмсэн болон амаржсаны эмнэлгийн хуудсыг тус тус 60 хоногийн хугацаагаар олгоно.

2.16.4. Даатгуулагч албан томилолтоор ажиллах буюу ээлжийн амралттай байх хугацаандаа байнга оршин суугаа газраасаа өөр газар байхдаа өвчилсөн бол тухайн газрын амбулаториор 5 хоног, эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн бол хэвтсэн хугацаанд нь тусламж үйлчилгээ үзүүлсэн эмнэлгийн байгууллага олгоно.

Гурав. Эмнэлгийн хуудсаар тэтгэмж бодож, олгох

3.1. Албан журмын даатгуулагч ердийн өвчин, ахуйн болон ҮОМШӨ-ий улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдсан, цалингүй чөлөө авсан зэрэг шалтгааны улмаас тухайн сард бүтэн ажиллаагүй, ажил олгогч нь ажилласан хоногт ногдох цалингаас "Нийгмийн даатгалын тухай хууль"-д заасан хувь хэмжээгээр тооцож, нийгмийн даатгалын санд шимтгэл төлсөн бол жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүснэ.

3.2. Журмын 2.5.1, 3.1-д заасны дагуу эрх үүссэн даатгуулагчид жирэмсний болон амаржсаны тэтгэмж тооцохдоо даатгуулсан хоногт ногдох цалинг оруулан тооцно.

3.3. Даатгуулагч ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдахаас өмнө тасралтгүй 3, түүнээс дээш сарын хугацаагаар тэтгэмжийн даатгалын шимтгэл төлж, ажилласан бол эмнэлгийн хуудсыг үндэслэн ХЧТА-ны тэтгэмжийг бодож олгоно. Тэтгэмжийг эмнэлгийн хуудас бичүүлсэн сарын өмнөх бүтэн ажилласан 3 сарын цалин хөлсний дунджаас тооцож олгоно. Харин эдгээр 3 сарын аль нэгэнд нь бүтэн ажиллаагүй бол түүнээс өмнөх бүтэн ажилласан дараалсан 3 сарын цалин хөлсийг сонгон тэтгэмж бодох сарын дундаж цалин хөлсийг тодорхойлно.

3.4. Улирлын чанартай ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг болон сул зогссон аж ахуйн нэгж, байгууллагатай хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг ажилтны ажиллаагүй хугацааны нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, сул зогсолтын үеийн олговроос тооцож төлсөн бол тэтгэмжийг даатгуулагчийн бүтэн ажилласан сүүлийн 3 сарын цалин хөлсний дунджаас бодно.

3.5. Хүүхэд асрах чөлөөтэй байх хугацаандаа дахин амаржсан эхэд жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг сүүлийн 12 сарын цалин, хөлсний дунджаас тооцно. Үүнд 2, 3 дахь удаагийн төрөлт мөн адил хамаарна.

3.6. Жирэмсний тэтгэмжийг эмнэлгийн хуудас авахын өмнөх сараас урагш 12 сарын цалин хөлсний дунджийг 21.2 хоногт хувааж, ногдох ажлын өдрөөр үржүүлж, албан журмын даатгуулагчид 100%-иар, сайн дурын даатгуулагчид 70%-иар бодож тус тус олгоно. Амаржсаны тэтгэмжийг жирэмсний тэтгэмж бодсон цалин хөлснөөс бодож олгоно.

3.7. Тэтгэмж тооцох цалин хөлсийг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

3.7.1. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж бодох нэг өдрийн дундаж цалин хөлсийг тодорхойлохдоо хөдөлмөрийн чадвар алдахаас өмнөх бүтэн ажилласан дараалсан 3 сарын цалингийн нийлбэрийг даатгуулагчийн 3 сард ажилласан ажлын өдөрт хуваана.

3.7.2. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу ажлын өдрөөр тооцно.

3.7.3. Ээлжийн ажилтай даатгуулагчийн ажилласан хоногийг ажлын өдөрт шилжүүлж тооцно.

3.7.4. Үндсэн ажил, үүргээс гадуур хэд хэдэн байгууллагад ажил үүрэг давхар гүйцэтгэж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагчид тэтгэмж бодох цалин давхар ажилласан бүх ажил олгогчийн олгосон цалин хөлсний нийлбэр дүнгээс тооцно.

3.8. Үндсэн ажил, үүргээс гадуур хэд хэдэн байгууллагад ажил үүрэг давхар гүйцэтгэж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагчид хөдөлмөрийн чадвараа түр алдсаны 6 дахь өдрөөс хойших хугацааны тэтгэмжийг дор дурдсанаар тооцож олгоно. Үүнд:

3.8.1. Даатгуулагчид хөдөлмөрийн чадвараа түр алдсаны 6 дахь өдрөөс хойших хугацааны тэтгэмжийг тухайн даатгуулагчийн үндсэн ажил олгогчийн нягтлан бодогч давхар ажилласан бүх ажил олгогчийн олгосон цалин хөлсний нийлбэр дүнгээс тооцон нийгмийн даатгалын байгууллагаас нэхэмжилнэ.

3.8.2. Цалин хөлсний нийлбэрийг тодорхойлохдоо даатгуулагчийн баталгаажсан нийгмийн даатгалын дэвтэр болон "Үндсэн ажлаас гадуур гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний орлогоос төлсөн шимтгэлийг бүртгэх хуудас"-ыг тус тус үндэслэнэ. Энэ тохиолдолд тэтгэмж тооцох сарын цалин хөлсний хэмжээ нь тухайн үед мөрдөж байгаа нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээнээс хэтрэхгүй байна.

3.8.3. Эмнэлгийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудсыг үндсэн ажлаас гадуур ажилласан байгууллагын тоогоор хувилж, хуулбарыг давхар ажилласан ажил олгогч бүрт өгөх үүргийг даатгуулагч хүлээнэ. Эмнэлгийн хуудасны эх хувь нь тухайн даатгуулагчийн үндсэн ажил олгогчийн санхүүгийн баримтад хадгалагдана.

3.9. Ажил олгогч нь ХЧТА-ны тэтгэмж олгосон жагсаалт (Маягт НД№36), эмнэлгийн хуудас, нэхэмжлэхийн хамт эмнэлгийн хуудсыг бичигдсэнээс хойш 28 хоногийн дотор нийгмийн даатгалын хэлтэс, тасаг (ажилтан)-т ирүүлж, тэтгэмжийн тооцоо хийнэ.

3.10. Нийгмийн даатгалын сайн дурын даатгуулагчийн авах тэтгэмжийг гэрээ байгуулсан Нийгмийн даатгалын хэлтэс банкаар дамжуулан даатгуулагчид олгоно.

3.11. Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох хугацааг хуанлийн хоногоор тооцно. Эмнэлгийн хуудасны бичилт амралтын өдрүүдэд тасарсан тохиолдолд үргэлжилснээр тооцож тэтгэмж олгоно.

3.12. Нийгмийн даатгалын байгууллага нь эмнэлгийн хуудас НД№4^а, НД№4^б, тэтгэмжийн тооцооны маягт НД№35,36-г тус тус үндэслэн ажил олгогчийн тэтгэмж тооцсон байдлыг шалган хэлтсийн нягтлан бодогчоор хянуулж, 21 хоногийн дотор тэтгэмжийг ажил олгогчийн харилцах дансанд шилжүүлнэ.

3.13. Нийгмийн даатгалын байгууллага эмнэлгийн хуудсыг ажил олгогч, эмнэлгийн байгууллагаас, тэтгэмж хүссэн өргөдлийг даатгуулагчаас цахимаар хүлээн авч шийдвэрлэж болно.

Дөрөв. Хориглох зүйл

4.1. Дараах тохиолдолд эмнэлгийн хуудас олгохгүй, шаардлагатай бол магадлагаа олгоно. Үүнд:

4.1.1 Өөрийн эрүүл мэндэд санаатайгаар гэм хор учруулсан, хуурамчаар өвчилсөн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, эмчилгээнээс санаатайгаар зайлсхийсэн нь тогтоогдсон;

4.1.2. Өдрийн эмчилгээ хийлгэсэн;

4.1.3. Халдварт өвчний улмаас хөл хорьж тусгаарласан;

4.1.4. Гоо сайхны мэс засал хийлгэсэн;

4.1.5. Хувийн эмнэлэгт амбулаториор эмчлүүлсэн;

4.1.6. Рашаан сувилалд сувилуулсан;

4.1.7. Хүүхэд үрчилж авсан эх;

4.1.8. Журмын 2.5.1.-д заасан хугацаанд тэтгэмжийн эрх үүсээгүй шалтгаанаар жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудсыг хойшлуулж олгохыг хориглоно.

4.2. Ердийн өвчин, ҮОМШӨ-ний улмаас хөдөлмөрийн чадвараа алдаж, тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгон ажиллаж буй даатгуулагч тухайн өвчний учир хөдөлмөрийн чадвараа түр алдсан тохиолдолд тэтгэвэр, тэтгэмжийг давхардуулан олгохгүй.

4.3. Журмын 3.9-д заасан хугацаа хэтэрсэн тохиолдолд тэтгэмж олгохтой холбоотой баримт бичгийг нийгмийн даатгалын байгууллага хүлээн авахгүй.

Тав. Эмнэлгийн хуудасны бичилт, олголтонд тавих хяналт

5.1. Энэ журмын 2.3-т заасан эмнэлгийн хуудас бичих эрх бүхий эмнэлгийн байгууллагын ерөнхий эмч /дарга, захирал, эрхлэгч/ эмнэлгийн хуудасны бичилт олголтын үндэслэлийг өвчний түүх, амбулаторын картын хөтлөлт, оношлогоо, шинжилгээнд тулгуурлан хяналт тавина.

5.2. Жирэмсний болон амаржсаны, сайн дурын даатгуулагчийн ХЧТА-ны эмнэлгийн хуудсыг нийгмийн даатгалын байгууллагын, ердийн өвчин, ахуйн болон ҮОМШӨ-ний улмаас ХЧТА даатгуулагчийн эмнэлгийн хуудсыг ажил олгогчийн санхүүгийн баримтад тус тус хадгалах ба ажил олгогч нь даатгуулагчид ХЧТА-ны тэтгэмж олгосон жагсаалт /НД№35, 36/-ыг 2 хувь үйлдэн нийгмийн даатгалын байгууллагаар хянуулсны дараа нэг хувийг нийгмийн даатгалын байгууллагад үлдээж, үлдэх хувийг нь өөрийн санхүүгийн баримтад хадгална.

5.3. Эмнэлгийн хуудасны олголт, зарцуулалтын тайланг сум, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага дараа улирлын эхний сарын 15-ны дотор, аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын байгууллага тухайн сарын 25-ны дотор гаргаж хэлтэс, газрын үйл ажиллагааны тайланд тусган хяналт тавьж ажиллана. Хэрэв энэ хугацаа амралт, нийтээр амрах баярын өдөртэй давхацвал өмнөх ажлын өдөр тайлагнана.

Зургаа. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

6.1. Нийгмийн даатгалын тухай болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү журмыг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдээр учирсан хохирлыг нөхөн төлүүлж, Нийгмийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь заалт болон Захиргааны хариуцлагын тухай хуулийн холбогдох заалтын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.2. Эмнэлгийн хуудас бичиж, олгохтой холбоотой гомдлыг эмнэлгийн байгууллага, тэтгэмж тооцож, олгохтой холбогдож гарсан гомдлыг нийгмийн даатгалын байгууллагын дэргэдэх Гомдлын шаардлагын зөвлөл тус тус хянан шийдвэрлэх үүрэгтэй.

ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ